

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/084/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 260512 Цахим хаяг: enkhdalai.d@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК
Захирал А.Сарангэрэл Утас: 99884842
Цахим хаяг: Gereltekhburtgelaudit3@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА

2025.03.28 № 07/1259
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн дуудлага худалдаанаас олсон орлогыг буруу бүртгэж, зөрчил, үр дагавар үүсгэсэн, нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоог хянаагүй зөрүүтэй тайлагнасан, албан томилолт болон урамшуулал илүү олгосон, цалин, шатахууны зардлыг буруу тооцоолсон, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож, цаашид ашиглах эсэхийг шийдвэрлээгүй, газрын асуудлыг шийдвэрлээгүй, цахим худалдан авалтыг зохион байгуулаагүй, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, заавар, журмын дагуу өөрчилж мөрдөөгүй зэрэг нийт 603.5 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18ы.2, 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.5, 20.2.6 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 дахь заалт, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 20 дугаар зүйлийн 21.2, гучин нэгдүгээр зүйлийн 31.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтуудыг зөрчсөн санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд гүйцэтгэлээр 52,843.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, 9,843.1 сая төгрөг буюу 22.9 хувиар давуулан биелүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ноогдол ашиг 2,835.6 сая төгрөг, түрээсийн орлогын 40.0 хувь 92.8 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ачаа тээврийн 38784, зорчигч тээврийн 46278, хүнс тээврийн 1496, тээвэрлэлтийн гэрээгүй нийтийн зорчигч тээврийн 4180, аюултай ачаа /тэсэрч дэлбэрэх бодис/ тээврийн 1326 тээврийн хэрэгслийг шалгаж, 1625 зөрчилд 188.9 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ нь тайлант онд 711,820 тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 723159 тээврийн хэрэгслийг хамруулж, 102.0 хувийн гүйцэтгэлтэй, 5058 хүнд мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгосон байна.

Тус төв нь тайлант онд 12 зорилт, 24 чиглэлийн хүрээнд нийт 96 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 73 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 22 арга хэмжээ хэрэгжих шатанд, 1 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, биелэлт 92.4 хувьтай гэж үнэлэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	26,676,245,304.00	33,164,957,168.12
1.1	Эргэлтийн хөрөнгө	26,676,245,304.00	33,164,957,168.12
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	24,176,097,182.24	29,202,085,105.43
1.1.2	Дансны авлага	140,852,998.61	92,727,314.40
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	784,047.00	6,409,414.21
1.1.4	Бусад авлага	39,723,837.59	7,785,404.79
1.1.6	Бараа материал	2,200,471,236.63	2,345,994,455.83
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	118,316,001.91	1,509,955,473.46
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	26,676,245,303.98	33,164,957,168.12
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	38,423,980,829.30	46,796,036,646.12
1.2.1	Үндсэн хөрөнгө	30,420,824,265.99	38,060,345,567.18
1.2.2	Биет бус хөрөнгө	7,951,305,647.11	8,735,691,078.94
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	51,850,916.20	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	38,423,980,829.30	46,796,036,646.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	65,100,226,133.28	79,960,993,814.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,138,280,951.84	234,335,615.99
2.1.1.3	Татварын өр	311,518,093.01	428,158,402.68
2.1.1.4	НДШ-ийн өр	-	145,177.44
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	262,913,795.29	149,929,462.87
2.1.1.8.1	Хойшлогдсон орлого /Хөрөнгө/	-	243,683,240.97
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	51,119,000.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,763,831,840.14	1,056,251,899.95
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	4,941,250,460.28	4,281,328,603.86
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,941,250,460.28	4,281,328,603.86
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,705,082,300.42	5,337,580,503.81
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн	241,840,000.00	241,840,000.00
2.3.2	хувийн	-	-
2.3.3	хувьцаат	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,149,852,787.34	3,131,491,948.04
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	19,295,044,750.84	28,057,707,591.78
2.3.5	Хуримтлагдсан ашиг /өмнөх үеийн/	34,708,406,294.68	31,891,265,305.65
2.3.6	Хуримтлагдсан ашиг /тайлант үеийн/	-	11,301,108,464.96
2.3.7	Эздийн өмчийн дүн	57,395,143,832.86	74,623,413,310.43
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	65,100,226,133.28	79,960,993,814.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	31,177,459,392.71	43,906,898,393.17
2	Борлуулалтын өртөг	27,712,051,664.40	36,181,740,526.09
3	Нийт ашиг(алдагдал)	3,465,407,728.31	7,725,157,867.08
4	Түрээсийн орлого	197,829,155.83	232,265,557.27
5	Хүүгийн орлого	921,271,902.84	717,840,802.93

**Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

6	Зорчигч тээврийн орлого	7,401,942,034.56	7,334,578,937.72
8	Бусад орлого	1,201,860,980.95	742,751,716.11
8.1	Орлогын дүн	9,722,904,074.18	9,027,437,014.03
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,091,892,779.45	3,179,023,733.36
12	Бусад зардал	1,266,095.24	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	65,585,954.44
17	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	-	(10,292,750.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	11,095,152,927.80	13,628,864,352.19
19	Орлогын татварын зардал	1,643,476,256.23	2,327,755,887.23
20	Татварын дараах ашиг (алдагдал)	9,451,676,671.57	11,301,108,464.96
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	9,451,676,671.57	11,301,108,464.96

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00	3,159,212,904.41	20,494,083,400.00	25,017,961,208.98	48,913,097,532.14
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				9,451,676,671.57	9,451,676,671.57
3	Өмчид гарсан өөрчлөлт			(1,199,038,649.16)	4,323,606.30	(1,194,715,061.61)
4	Зарласан ногдол ашиг				(684,112,010.00)	(684,112,010.00)
5	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(9,360,117.07)		918,556,817.83	909,196,700.76
6	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00	3,149,852,787.34	19,295,044,750.84	34,708,406,294.68	57,395,143,832.86
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				18,362,020.97	18,362,020.97
8	Залруулсан үлдэгдэл					
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				11,301,108,464.96	11,301,108,464.96
10	Өмчид гарсан өөрчлөлт			8,762,662,840.94		8,762,662,840.94
11	Зарласан ногдол ашиг				(2,835,503,010.00)	(2,835,503,010.00)
12	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(18,360,839.30)			(18,360,839.30)
13	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00	3,131,491,948.04	28,057,707,591.78	43,192,373,770.61	74,623,413,310.43

Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	43,242,219,397.10	54,649,736,673.26
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	43,200,141,240.00	51,626,529,925.35
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	42,078,157.10	405,000.00
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	-	3,022,801,747.91
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	29,836,625,606.59	44,467,514,712.72
	Ажиллагчдад төлсөн	17,046,941,165.58	22,227,096,358.40
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,264,063,654.70	3,079,205,186.42
	Бараа материал худалдан авахад төлсөн	559,999,036.00	653,159,128.09
	Ашиглалтын зардалд төлсөн	2,662,102,169.05	3,244,605,636.14
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	530,872,095.09	805,590,677.82
	Хүүгийн төлбөрт төлсөн	112,923,812.94	115,758,025.60
	Татварын байгууллагад төлсөн	3,327,808,758.40	7,892,778,199.78
	Даатгалын төлбөрт төлсөн	60,846,713.00	83,292,292.00
	Бусад мөнгөн зарлага	3,271,068,201.83	6,366,029,208.47
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,405,593,790.51	10,182,221,960.54
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	921,271,902.84	717,840,802.91
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого	921,271,902.84	717,840,802.91
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,757,077,297.00	2,500,609,042.38
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,056,110,897.00	2,460,964,951.47
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	700,966,400.00	39,644,090.91
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,835,805,394.16	-1,782,768,239.47
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,229,680,289.12	3,373,465,797.88
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	545,558,279.12	537,962,787.88
	Төлсөн ногдол ашиг	684,122,010.00	2,835,503,010.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,229,680,289.12	-3,373,465,797.88
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	10,340,108,107.23	5,025,987,923.19
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,835,989,075.01	24,176,097,182.24
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,176,097,182.24	29,202,085,105.43

Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
A	Орлого төвлөрүүлэлт					-
1	Техникийн хяналтын үзлэгийн орлого	14,571,278.8	14,800,000.0	16,467,002.6	1,667,002.6	111.3
2	Тээвэр зохицуулалтын орлого	13,837,700.5	17,630,000.0	21,697,238.2	4,067,238.2	123.1
3	Хөдөлгөөний хяналт, удирдлагын орлого	1,946,790.1	1,200,000.0	1,393,588.0	193,588.0	116.1
4	Бүртгэлийн үйлчилгээний орлого	8,430,738.1	8,600,000.0	11,929,085.8	3,329,085.8	138.7
5	Үйл ажиллагааны бусад орлого	2,113,855.9	770,000.0	1,447,420.8	677,420.8	188.0
	Нийт дүн	40,900,363.5	43,000,000.0	52,934,335.4	9,934,335.4	122.9
1	Цалин хөлс	16,302,228.1	24,337,240.0	23,705,317.5	631,922.5	97.4
2	Цалингийн нэмэгдэл, урамшуулал	1,106,725.6	1,300,000.0	424,685.1	875,314.9	32.7
3	Нийгмийн даатгалын шимтгэл	2,279,128.6	3,421,827.4	3,252,298.1	169,529.3	95.0
4	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	194,499.9	217,000.0	187,800.6	29,199.4	86.5
5	Бичиг хэргийн зардал	151,942.8	170,000.0	169,923.0	77.0	100.0
6	Ашиглалтын зардал	1,151,862.4	1,376,219.3	1,258,370.3	117,849.0	91.4
7	Хангамжийн материалын зардал	141,806.7	180,000.0	176,311.3	3,688.7	98.0
8	Төлбөр хураамжийн зардал	267,934.4	257,194.5	238,161.8	19,032.7	92.6
9	Сургалтын зардал	92,145.9	110,000.0	104,550.8	5,449.2	95.0
10	Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/	1,566,966.6	1,800,000.0	1,799,135.2	864.8	100.0
11	Тогтмол үйлчилгээ, засварын зардал	225,417.0	250,000.0	182,276.1	67,723.9	72.9
12	Шатахууны зардал	304,107.3	510,560.0	487,413.9	23,146.1	95.5
13	Даатгалын зардал	32,834.1	45,000.0	44,306.4	693.6	98.5
14	Утас, интернэтийн зардал	271,495.1	330,000.0	310,083.8	19,916.2	94.0
15	Томилолтын зардал /унаа, буудал, хоол/, /дотоод, гадаад/	466,872.4	1,080,000.0	870,756.1	209,243.9	80.6
16	Хэвлэлийн зардал	384,165.7	370,000.0	368,399.5	1,600.5	99.6
17	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал	117,775.8	150,000.0	125,941.1	24,058.9	84.0
18	Банкны үйлчилгээний зардал	76,667.4	150,000.0	149,952.4	47.6	100.0
19	Цэвэрлэгээний материалын зардал	23,202.4	23,000.0	22,856.9	143.1	99.4
20	Зар сурталчилгааны зардал	165,876.5	250,000.0	205,544.5	44,455.5	82.2
21	Бизнес уулзалт, арга хэмжээний зардал	183,787.3	180,000.0	176,332.6	3,667.4	98.0
22	Аудитын зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс	18,000.0	11,000.0	11,000.0	-	100.0
23	Өвөлжилтийн бэлтгэл хангах зардал	91,842.8	160,000.0	118,985.5	41,014.5	74.4
24	Хөдөлмөр хамгааллын зардал	309,231.9	533,958.8	466,333.8	67,625.0	87.3
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	190,296.9	269,000.0	223,786.9	45,213.1	83.2
26	Сэлбэг хэрэгслийн зардал	233,993.9	240,000.0	234,290.4	5,709.6	97.6
27	Шагнал урамшуулал	9,919.5	15,000.0	7,231.8	7,768.2	48.2
28	Ахмадын жилийн зардал	110,901.5	150,000.0	122,152.4	27,847.6	81.4
29	Хог хаягдал устгах	14,625.7	23,000.0	20,365.2	2,634.8	88.5
30	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	115,166.8	120,000.0	81,750.0	38,250.0	68.1
31	Зээлийн хүүгийн зардал	54,446.4	50,000.0	47,067.0	2,933.0	94.1
32	Ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэх зардал	200,000.0	300,000.0	299,500.0	500.0	99.8
33	Болзошгүй ажлын зардал	234,938.9	300,000.0	295,048.2	4,951.8	98.3
34	Элэгдлийн зардал	2,714,403.1	2,820,000.0	3,117,542.9	(297,542.9)	110.6
	Нийт дүн	29,805,209.4	41,500,000.0	39,305,471.1	2,194,528.9	94.7
1	Татварын өмнөх ашиг/алдагдал	11,095,154.1	1,500,000.0	13,628,864.4	(12,128,864.4)	908.6
2	Орлогын албан татвар	1,643,470.3	150,000.0	2,327,755.9	(2,177,755.9)	1,551.8
3	Цэвэр ашиг/алдагдал	9,451,683.9	1,350,000.0	11,301,108.5	(9,951,108.5)	837.1
4	Ногдол ашгийн өгдөг	684,122.0	2,288,032.0	2,835,503.0	(547,471.0)	123.9

**Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

6	Төсөвт	8,423,764.8	9,988,441.2	14,093,625.4	(4,105,184.2)	141.1
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох	0.73	0.97	0.74	0.2	76.9
5	Хөрөнгө оруулалт	8,179,693.6	25,684,257.6	7,561,374.2	(18,122,883.5)	29.4
8	Нийт авлага	181,360.9	120,000.0	106,922.1	13,077.9	89.1
9	Нийт өр төлбөр	7,705,082.3	4,028,000.7	5,337,580.5	(1,309,579.8)	132.5

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой төв албаны. 723,818.4 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад тохируулах бичилт хийлгэж, баталгаажуулав.

Төв албаны санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэгтгэсэн тайланд 14 салбарт үнэ төлбөргүй шилжин ирсэн нийт 257,356.1 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг хойшлогдсон орлого дансанд бүртгэж тайлагнаагүй, нөөцийн өр төлбөр дансанд бүртгэж, тайлагнасан.	1	257,356.1	-	-	1	257,356.1	1	257,356.1	-	-	-	-
	Дүн	1	257,356.1	-	-	1	257,356.1	1	257,356.1	-	-	-	-
Тээврийн хэрэгслийн улсын дугаарын дуудлага худалдаатай холбоотой холбогдох тооцооллуудыг буруу бэлтгэснийг тохируулах бичилт хийсэн. Үүнд:													
1	Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дуудлага худалдаанаас олсон орлогыг 85,487.7 мянган төгрөгөөр бууруулан бусад орлого дансанд бүртгэж, уг дүнгээр борлуулалтад ногдох НӨАТ-ыг илүү тайлагнасан;	1	85,487.7	-	-	1	85,487.7	1	85,487.7	-	-	-	-
2	Данс хоорондын дотоодын шилжилт хөдөлгөөний 358,083.0 мянган төгрөгийг дэнчин буцаалтын өглөгөөр тооцсон;	1	358,083.0	-	-	1	358,083.0	1	358,083.0	-	-	-	-
3	Банкны үйлчилгээний шимтгэлийн 82.4 мянган төгрөг, данс андуурсан гүйлгээний 7,214.2 мянган төгрөгийг тооцоолоогүй;	1	7,296.6	-	-	1	7,296.6	1	7,296.6	-	-	-	-
4	Хүүхдийн төлөө санд төвлөрүүлэх орлогыг 15,595.0 мянган төгрөгөөр илүү шилжүүлж, авлагаар тайлагнаагүй;	1	15,595.0	-	-	1	15,595.0	1	15,595.0	-	-	-	-
	Дүн	4	466,462.3	-	-	4	466,462.3	4	466,462.3	-	-	-	-
	Нийт дүн	5	723,818.4	-	-	5	723,818.4	5	723,818.4	-	-	-	-

Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Төв албаны санхүүгийн тайланд хийсэн аудитаар: Нийт 554,916.1 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 8,714.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 105,189.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлж, 441,012.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

Төв албаны санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөнхий нягтлан бодогч нь анхан шатны баримтад үндэслээгүй дуудлага худалдааны орлогыг бууруулж, борлуулалтад ногдох НӨАТ-ыг 85,487.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэж, татварын тодорхойлолтоорх НӨАТ-ын өглөгийн үлдэгдлийг санхүүгийн тайлан дахь НӨАТ-ын өглөгийн үлдэгдлээс 75,810.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, өмнөх оны аудитаар дуудлага худалдаатай холбоотой зөрчил гаргасан нь давтагдсан;	1	75,810.1	-	-	1	75,810.1	-	-	-	-	-	-
2	Газрын захирлын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн удирдамжаар 1 ажилтны ХБНГУ-д сургалтад хамрагдах томилолтын зардалд 28,195.1 мянган төгрөг батлагдсанаас 5,914.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн байна.	1	5,914.2	1	5,914.2	-	-	-	-	-	-	-	-
3	Газрын захирлын 2024 оны Б/139 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан 1 ажилтанд мөн газрын захирлын 2024 оны А/169 дугаар тушаалаар 2024 оны 2 улирлын үр дүнгийн урамшуулалд 2,800.00 мянган төгрөг олгосон байна.	1	2,800.0	1	2,800.0	-	-	-	-	-	-	-	-

Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

4	Нэгтгэсэн тайлангийн авлагын дансны эцсийн үлдэгдэлд 2 салбарын 7 байгууллагаас авах 4-5 жилийн насжилттай 3,011.8 мянган төгрөгийн, төв албаны 2 хувь хүнээс авах 7 жилийн насжилттай 7,897.9 мянган төгрөгийн, нийт хугацаа хэтэрсэн, он дамжсан 10,909.7 авлагатай, барагдуулаагүй байна. Мөн зорчигч тээврийн 2 байгууллагад өгөх 12,132.4 мянган төгрөгийн эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	23,042.1	-	-	1	23,042.1	-	-	-	-	-	-
5	Тайлант онд ЗТС-ын 2024 оны А/153 дугаар тушаалаар гадаад албан томилолтын зардал гаргахыг даалгасныг үндэслэн 2024 оны А/188 дугаар тушаалаар БНХАУ-ын ӨМӨЗО-д зохион байгуулагдсан хуралд оролцсон ЗТХЯ-ны нэр бүхий 2 албан хаагчид 6,336.9 мянган төгрөг зарцуулсан, өмнөх аудитаар гарсан алдааг давтан гаргасан байна.	1	6,336.9	-	-	1	6,336.9	-	-	-	-	-	-
6	НБББББ-ийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, заавар, журмын дагуу өөрчилж, үйл ажиллагаандаа мөрдөөгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
7	АТҮТ нь Драгон холдинг ХХК-тай 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр "Үл хөдлөх эд хөрөнгө худалдан, худалдан авах гэрээ" байгуулан "Dragon bus terminal" төвийн 1 давхрын 979.14 м2 талбайг 2,883,463.00 мянган төгрөгөөр худалдан авч, 2016-2020 онд нийт 2,837,344.00 мянган төгрөгийг төлж барагдуулсан. 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан гэрээгээр өмнөх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан талбайг өөрчлөх талаар хэлэлцсэн байна. Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд	1	51,119.0	-	-	-	-	1	51,119.0	-	-	-	-

**Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

	2016 онд үүссэн, тус Драгон холдинг ХХК-тай байгуулсан гэрээний дагуух 51,119.00 мянган төгрөгийн он дамжсан өглөгийн үлдэгдэлтэй, шийдвэрлэгдээгүй байна.												
8	Төв албаны үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 167 ширхэг 267,086.9 мянган төгрөгийн биет болон биет бус хөрөнгө бүртгэлтэй, дахин үнэлэх, цаашид ашиглах шаардлагатай эсэхийг шийдвэрлээгүй байна.	1	267,086.9	-	-	-	-	1	267,086.9	-	-	-	-
9	Тайлант онд албан хэрэгцээнд 126,000.00 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй бэлтгэсэн байна.	1	122,807.0	-	-	-	-	1	122,807.0	-	-	-	-
	Дүн	9	554,916.2	2	8,714.2	3	105,189.1	4	441,012.9	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Төв албаны бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

1	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									

**Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

Захирлын 2024 оны А/13 тушаалаар батлагдсан Үйлдвэрийн газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх Дорноговь аймгийн Замын үүд суманд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн байр шинээр барих ажил, Замын үүд суманд шинээр баригдах автотээврийн үндэсний төвийн барилгын хүчитгэлийн зураг болон төсөв шинэчлэх ажил, нийт 2 ажил техникийн нөхцөлөөс шалтгаалан хэрэгжээгүй байна	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	-	1	-

3.4 Харьяа салбаруудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар: Нийт 48,643.0 мянган төгрөгийн 13 зөрчил илэрснээс 2,601.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 46,041.4 мянган төгрөгийн 10 зөвлөмж өгч, 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх санал өгсөн байна.

Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Салбарууд	Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Нийгмийн даатгалын тайлангаар 97.3 мянган илүү төлөлттэй байхад тайлагнаагүй.	1	97.3	-	-	-	-	1	97.3	-	-	-	-
2	Дархан-Уул аймаг дахь Автотээврийн үндэсний төв	ХНХС-ын 2021 оны "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-н 1.5 дахь хэсэгт зааснаар 1 цагийн дундаж цалин хөлсийг тооцоход программын тооцооллын алдаа гарч, 10 ажилтны 1,808.3 мянган төгрөгийн илүү цаг болон шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон.	1	1,808.3	1	1,808.3	-	-	-	-	-	-	-	-

**Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

3	Орхон аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Тайлант хугацаанд 1 албан хаагчийн 64.5 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон байна.	1	64.5	-	-	-	-	1	64.5	-	-	-	-
4	Төв аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Газрыг бүртгэлд тусгах, бүртгэлтэй газрын хэмжээг зөв болгон залруулах	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
5	Өмнөговь аймаг, Цогтцэций суман дахь Автотээврийн үндэсний төв	9800 ӨМӨ дугаартай Ланд-76 автомашинд 17,000.0 мянган төгрөгийн моторын эд сольсон боловч капиталжуулаагүй. Хөрөнгийг эхний улиралд багтаан капиталжуулах.	1	17,000.0	-	-	-	-	1	17,000.0	-	-	-	-
6		Цалингийн тооцооллыг түүвэрлэн шалгахад 5 албан хаагчид 3,031.8 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговрыг цалинтай нь давхардуулан олгосон.	1	3,031.8	-	-	-	-	1	3,031.8	-	-	-	-
7		Барилгын зураг төсөв нийт 19.900.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй.	1	19,000.0	-	-	-	-	1	19,000.0	-	-	-	-
8	Ховд аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд аудитын байгууллагад ирүүлээгүй хугацаа хоцроосон.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
9		Тайлант онд худалдан авсан шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, сумдад явсан км өмнөх сард явсан км-с зөрүүтэй, тухайлбал Баруун 5 аймагт ямар шийдвэрээр ажилласан нь тодорхойгүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

**Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

10		Жаргалант сумын Засаг даргын захирамжаар 2016 онд Ховд автотээврийн салбарт 56810.3м2 газрыг олгосон. Тухайн үед газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгээгүйгээс 3000 м2 газрыг давхардуулж олгосон. Уг газар дээр авто вокзалын барилга баригдаж эхэлсэнтэй холбоотойгоор газрын маргаан үүссэн.	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
11	Хөвсгөл аймаг дахь Автотээврийн үндэсний төв	Нийт 793.3 мянган төгрөгийн зөрчлийг аудитын хугацаанд залруулж, төлбөрийн акт тогтоосон.	1	793.3	1	793.3	-	-	-	-	-	-	-	-
12	Сонгинохайрхан Техник хяналтын үйлчилгээний төв	Худалдан авсан 6.847.8 мянган төгрөгийн бараа, материалыг цахим дэлгүүрээс худалдан аваагүй.	1	6,847.8	-	-	-	-	1	6,847.8	-	-	-	-
13		Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайлан шилэн дансанд мэдээлээгүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн			13	48,643.0	2	2,601.6	-	-	10	46,041.4	-	-	1	-